

НИЦШЕ СУДЛАЛЫН ЗАРИМ ЧУХАЛ АСУУДЛААС

Б.ИЧИНХОРЛОО

МУИС, НШУС, Философийн тэнхим ; Түлхүүр үг:

Ницшегийн намтар судлал

Онолын ницше судлал

Ф.Ницшегийн философийн талаархи зэрэг үнэлэмж

Ф.Ницшегийн философийн талаархи сөрөг үнэлэмж

<<Заратустра ингэж өгүүлэв>> зохиолын баатруудын дүр

Оршил: Германы философич Фридрих Ницше (1844-1900)-гийн үзэл санааны өвийг тойрсон онолын ба үзэл суртлын маргаан өнөөг хүртэл үргэлжилж байдаг. Түүнийг зарим хэсэг нь, ялангуяа католик шашны үзэл сурталчид солиотой, галзуу бүтээлч гэж үздэг байхад олон тооны нэр хүнд бүхий философиос Ф.Ницшег орчин үеийн философидолтын хэв маягийг тодорхойлогч хэмээн өндөрт өргөдөг ажээ. Зөвхөн энэ хоёрхон баримт гэхэд Ф.Ницшегийн философи өвийг төдийгүй хувийн амьдралынх нь замналыг няхуур нямбай судалж, үзэл сурталжилтаас ангижирсан дүгнэлт гаргах ажиллагаа чухал ач холбогдолтой юм.

Нэг. Дэлхий дахин дахь ницше судлалын далайц, монголчуудын философи амьдралд түүний холбогдох байдал

Өрнөдөд болон марксист-ленинист сургаалын дагуу социализмыг байгуулж ирсэн орнуудад Ф.Ницшегийн үзэл санааны өвийг төдийгүй түүний хувийн амьдралын түүхийг судлах үйл ажиллагаа XX зууны туршид үргэлжилж ирсэн байна.

Тиймээс ф.Ницше судлалыг хоёр үндсэн бүлэгт хувааж болох мэт. Нэг нь Ф.Ницшегийн намтар судлал юм. Түүний хамгийн том төлөөлөгчид нь Ф.Ницшегийн эмэгтэй дүү Элизабет Фёрстер Ницше¹, Карл Албрехт Бернулл² зэрэг герман зохиогч нар юм. Мөн Ф.Ницшегийн намтрын судалгаанд томоохон хувь нэмэр оруулсан хүн бол М.Маги³ аж.

Ф.Ницшегийн намтрыг судлах нь зөвхөн сониучирхал, хүндэтгэл, бэлгэдлийн шинжтэй биш ажээ. Учир нь, Ф.Ницшегийн философи үзэл бол энэхүү сэтгэгчийн хувийн араншин, хувийн амьдралын онцлогтой, түүний дотор өвчиндөө шаналснаас үүдэлтэй сэтгэгдэлтэй нь холбоотойг судлаачид өгүүлдэг билээ.

Гэхдээ Ницше судлалын ихэнх нь Ф.Ницшегийн амьдрал, үйл ажиллагааных нь түүх, зарим бүтээлийнх нь агуулга хоёрыг холбон тайлбарлаж ирсэн байна. Тийм учраас ницше судлалын энэ бүлэгт товч, оновчтой нэр өгөхөд зарим талаар бэрхшээлтэй. Гэсэн ч түүний илэрхийлдэг гол агуулга ба үндсэн зорилгыг нь иш үндэс болгон "онолын ницше судлал" хэмээн энэ өгүүлэлд нэрлэхээр болзон тогтсон болно.

Онолын ницше судлал нь Ницшегийн намтар судлалын үр дүнтэй зайлшгүй холбогдох учиртай. Энэ нь Ф.Ницше өөрөө: "Би номнууддаа ямагт бүх бие, амьдралаа бичдэг байсан. Цэвэр оюуны асуудал гэж юу байдаг нь надад тодорхойгүй байдаг"⁴ гэж бичсэнтэй нилээд нийцдэг.

Үүнтэй холбогдуулан бас нэг ишлэл дурдахад германы судлаач Рудольф Штейнер "Фридрих Ницшегийн дүр төрх ба психопатологи" гэдэг өгүүлэлдээ: Ф. Ницше "өөрийнхөө эргэцүүлүүдээр жинхэнэ эсрэг этгээдийг бараг хэзээ ч бий болгодоггүй. Тэрээр анхандаа довтлох тааламжит объектоо маш хачин янзаар өөртөө сэтгэн бүтээж, дараа нь бодит байдлаас маш хол хий бодолтой тэмцдэг"⁵ гэж бичсэн байдаг.

Р.Штейнерийн эл дүгнэлтийг зөвшөөрөхгүй хүн гарахыг үгүйсгэх аргагүй юм. Тухайлбал диссертант миний бодлоор Ф.Ницшед (Р.Вагнер гэх мэт) олон бодит сэргэлдэгч бий болсон бөгөөд Германы энэ сэтгэгчийн философи үндэслэл, баримтлалууд нь бодит байдлаас хөндий биш, харин ч нийгмийн зарим зориулалтанд маш ойр байж, улмаар германд үндсэрхэг үзэл дэвжихэд, христын шашны ёс суртахууны нөлөөг бууруулахад багагүй нөлөөлсөн гэмээр байдаг.

Гэхдээ Р.Штейнер дээрх дүгнэлтээ зөвтгөхдөө нэг чухал үндэслэгээг гаргажээ. Үүнд, Р.Штейнерийн тэр үндэслэлийг дурдахад Ф.Ницшед бодит дайсан, бодит үзэл байгаагүйн шалтгаан гэвэл "эрээр "мөн чанартаа ямар нэг гадны дайсантай хэзээ ч тэмцээгүй бөгөөд харин ямагт өөрөө өөртэйгөө тэмцэж байв"⁶

Р.Штейнерийн эл бичсэнийг хэрхэн ойлгож байгаагаа илэрхийлбэл Ф.Ницше аль нэг хүний бэлэн философи сургаалыг шууд нэр цохон ноцож, шүүмжилдэггүй, харин цэвэр өөрийн үнэлэмж, сэтгэх хэв маяг, бичлэгийн стилийн үүднээс өөртөө шүүмжилэлтэй хандаж үүгээрээ өөрөө өөрийнхөө дайсан болох замаар өөрийн гэсэн философидолт явуулж, философи баримтлалууд боловсруулсан гэж тэрээр (Р.Штейнер) үзсэн юм. Хэрэв миний тайлбар зөв байгаа аваас Р.Штейнерийн энэ дүгнэлт нь Ф.Ницше өөрийн номнуудаа хэрхэн бүтсэн тухай дээр өгүүлсэнтэй авцалдаж байна.

Ф.Ницше тийнхүү өөрөө хэлж, олон судлаач түүний нь даган баримталсан логик дагуу ХХ зуунд ницше судлалыг хөгжүүлэхэд Карл Ясперс⁷, Мартин Хайддегер⁸, Жак Деррида⁹, Мишель Фуко¹⁰, Жиль Деллэз¹¹ зэрэг философичид онцгой хувь нэмэр оруулсан ажээ.

Түүнээс гадна социализмыг байгуулж байсан орнуудын философичид ницше судлалын марксист-ленинист хувилбарыг бий болгосон билээ. Энд зөвлөлтийн зарим философичдыг онцлон дурдах шаардлагатай байдаг.¹²

Социализмыг байгуулж байсан орнуудын философичид улс орноо коммунист дэглэмээсээ татгалзсан нөхцөлд философийн асуудлыг плюралист байрнаас авч үзэх бололцоотой болсон нь ницше судлалд шууд хамаарч байна. Үүний нэг гэрч нь оросын философич К.С.Свасьян 1990 онд Фридрих Ницшегийн зарим гол бүтээлийн 2 бөгийг бүрдүүлэн редакторлож хэвлүүлэхдээ тэдгээрт зориулж бичсэн удиртгал өгүүлэл юм¹³.

Одоо Монголд ницше судлал ямар төвшинд байгаа талаар дурдъя. Монголчууд Ф.Ницшегийн бүтээлийг авч үзэх байдал 1990 оноос өмнө ч, түүнээс хойш ч онолын төвшинд авч үзэх байдал хангалтгүй, харин сурталчилгааны төвшинд байгаа гэж ерөнхийд нь хэлж болно.

1990-ээд оноос өмнөх олон арван жилд эрос хэлнээс монгол хэлэнд хөрвүүлсэн философийн зарим сурах бичиг дэх "орчин үеийн хөрөнгөтний философийг шүүмжлэх нь" гэдэг үзэл суртлын уур амьсгалтай бүлэгт болон философийн толь бичигт Ф.Ницшегийн философийг марксизм-ленинизмийн үүднээс зөвхөн шүүмжилдэг байлаа¹⁴. Бас тэр үед манай зарим философич Ф.Ницшегийн философийг өөрийн бичсэн номонд хамруулж, ингэхдээ түүнийг мөн л марксизм-ленинизмийн үзэл санааны үүднээс зөвхөн шүүмжилж байв¹⁵.

1990-ээд оноос хойш манай зохиогчид Ф.Ницшегийн философийг авч үзсэн тохиолдолдоо плюралист байр суурь гаргасан байна¹⁶. Тэр нь 1990-ээд оноос өмнөхийн адил сурталчилгааны төвшний тайлбар юм.

Үүний зэрэгцээ Ф.Ницшегийн намтарт¹⁷ болон философи баримтлалуудад¹⁸ нь холбогдох нилээд судалгааны шинжтэй бэсрэг боловч зарим бүтээлийг манай судлаачид эхэллээ. Энэ нь монголд ницше судлал үүсэж байгаагийн чухал нотолгоо мөн.

Орчин үе дэх философийн төдийгүй нийт оюуны соёлын амьдралд ницше судлал чухал байр суурь бүхий байгаа ажээ. Оросын эрдэмтэн В.С.Малахов, В.П.Филатов нарын эрхлэн хэвлүүлж Москвад анх 1990 онд, улмаар 1998 онд нэмэлт оруулж засварлан 2 дахь удаагаа хэвлүүлсэн

хамтын бүтээл философийн тольд тэмдэглэснээс үзвэл¹⁹ эдүгээ ницше судлалын олон улсын сургууль бий болсон байна. Энэ байгууллага "Nietzsche-Studien" гэдэг нэртэй жил тутмын сэтгүүлтэйгээс гадна өөр хэд хэдэн хэвлэлийн төв, эрдэм шинжилгээний тогтмолжсон бага хурлуудын сүлжээ бүхий байгууллага юм. Ницше судлалын олон улсын сургуулийн үйл ажиллагаа нь хэдийгээр Ф.Ницшегийн үзэл санааг сурталчлах зорилготой боловч угтаа энэ үйл ажиллагаа шинжлэх ухааны судалгааны төвшинд явагддаг байна.

Гэхдээ энэ нь ницше судлал авч үзэх асуудлаа, шийдвэрлэх зорилтуудаа эдүгээ дуусгасан гэсэн үг биш юм. Ф.Ницше философийн түүхэнд хэрхэн хандаж, тэрээр ямар ямар төлөөлөгчдөд талархалтай, эсвэл шүүмжлэлтэй хандаж байсан бэ?, тэрээр өөрөө ХХ зууны философид төдий биш, ер нь оюуны нийт соёлд хэрхэн нөлөөлж ирсэн бэ? гэсэн асуултууд гарахад тэдгээрт өгсөн өнөөгийн хариултууд хамарсан зүйлийнхээ багтаамж, шийдвэрлэсэн үр дүнгийнхээ зөвшөөрөгддөг төвшин зэргийн аль алинаар хангалтгүй байгаа юм. Үүнийг орчин үеийн судлаачдын холбогдох өөр өөр дүгнэлт, Ф.Ницшегийн үзэл санааны өвд ханддаг ялгаатай үнэлэмжүүд гэрчилдэг.

Ийнхүү Ф.Ницшегийн философийг агуулгынх нь үүднээс оновчтой нээн тайлбарлах, түүний онолын нөлөөг нь бүрэн илрүүлэх, нийгмийн ямар зориулалтанд уг онолыг ашиглаж ирсэн ба хэийд ашиглаж болох янз бүрийн хувилбарыг тогтоох зэрэг онол, практикийн шаардлагуудын үүднээс Ф.Ницшегийн философийг судлахын ач холбогдол эдүгээ ч хэвээрээ байгаа билээ.

Хоёр. Ф.Ницшегийн философийн талаархи өөр өөр үнэлэмжийн зарим үндэслэгээ

Философи, шашны сургаалын төлөөлөгчид Ф.Ницшегийн философийг өөр өөрөөр үнэлдэг тухай энэ өгүүллийн өмнө цухас дурдсан билээ. Гэвч тэр дурдсан маань Ф.Ницшегийн философид, энэ сэтгэгчийн бие, сэтгэлийн эрүүл мэндийн байдалд басамжилж хандсан байр суурийг зөвхөн шашны үзэл сурталчид гаргасан гэсэн санаа биш билээ. ХХ зууны Өрнөдийн философийн зарим томоохон төлөөлөгч Ф.Ницшегийн философи хувь заяаг нэн явцгүй хэмээн шууд бичсэн байдаг. Тухайлбал: энд ХХ зууны томоохон сэтгэгчдийн нэг, английн философич Бертран Рассел (1872-1970)-ийг дурдахыг хүсч байна. Тэрээр өрнөдийн философийн түүх, онолыг олон арван жил судалсныхаа үр дүнг гаргаж бичин 1945 онд анх хэвлүүлсэн

бөгөөд түүнээс хойш олон удаа дахин хэвлүүлсэн "Өрнөдийн философийн түүх" номондоо Ф.Ницшег онтологи, эпистемологийн салбарт жичдээ шинэ онол бүтээгээгүй бөгөөд харин шашны шүүмжлэл, ёс зүй хоёр нь их нөлөө бүхий байдаг гэж дурдсан юм²⁰. Гэхдээ нөлөө бол заавал эерэг байх албагүй нь ойлгомжтой. Тухайлбал, Б.Рассел бичихдээ: "... миний хувьд Ницше зохисгүй хүн бөгөөд яагаад гэвэл тэрээр зовлонг бясалгахыг таашааж, яагаад гэвэл их занг үүргийн төвшинд өргөмжилж, яагаад гэвэл түүний хамгийн их бахархдаг хүмүүс нь хүмүүсийг амьдралаас нь салгах чадвараараа алдаршсан байлдан эзлэгч нар байдаг юм. Гэвч зохисгүй, гэхдээ дотоод зөрчилгүй аливаа ёс зүйн эсрэг шиг Ф.Ницшегийн философийн эсрэг шийдвэрлэх үндэслэгээ нь баримтын салбарт биш, харин догдлолын салбарт байдаг. Түгээмэл хайрыг Ф.Ницше үл тоомсорлодог бөгөөд харин би түүнийг энх тайвны тусын тулд хүсэж, бүхнийг хөдөлгөгч хүч мөн хэмээн тооцдог. Ф.Ницшег баримтлагч нарт өөрийн гэсэн олон аз тохиосон бөгөөд гэвч түүнд удахгүй төгсгөл ирнэ гэж бид найдаж болно"²¹ хэмээн гол нь ёс суртахууны философид хандсан дүгнэлт хийсэн юм.

Түүнээс гадна зарим философич Ф.Ницшег хэрэг дээрээ философич биш гэж үнэлж, ингэхдээ германы энэ сэтгэгчийг үзэл бодлоо онолын хэлээр илэрхийлээгүй, ер нь философийн систем бий болгоогүй, өөрөөр хэлбэл олон бүтээл нь тус тус саланги сэтгэлгээг илэрхийлсэн афоризмуудын эмхтгэл болж байдгийг үндэслэгээ болгодог байна.²²

Нөгөөтэйгүүр Ф.Ницшегийн философийг бүхэлд нь биш юм гэхэд түүний боловсруулсан олон философи баримтлал, томъёоллыг ямар нэг байдлаар ашиглаж, энэ философид хүндэтгэлтэй хандсан нөлөө бүхий цөөнгүй философич байдгийг өгүүллийнхээ эхэнд дурдсан билээ. Энд Жиль Делёзийг онцолж дурдъя. Тэрээр Ф.Ницшег судлаад "Ф.Ницше ба философи" гэдэг зохиолыг 1962 онд хэвлүүлж байсан аж. Эл зохиолд Ф.Ницшегийн боловсруулсан түгээмэл шүүмжлэх зарчмыг баримтлах үндсэн дээр диалектикт ярьдаг үгүйсгэлийн үгүйсгэл бол адилсал дахь үгүйсгэлийг халахуй мөн гэж тайлбарлаад: угтаа үгүйсгэл халагддаггүй. Учир нь, сэтгэхүй цаг ямагт, ялгааг, ялгарлыг агуулдаг гэж үзсэн байна.

1864 онд Францын Руаймонд Ф.Ницшегийн философиор коллоквиум зохиогдож, улмаар Ж.Делёз "Ф.Ницше ба философи" зохиолынхоо гол гол санааг болон энэ коллоквиумын үндсэн үр дүнг багтаасан "Ницше" гэдэг ном 1965 онд хэвлүүлсэн байна. Тэрээр энэ бүтээлдээ Ф.Ницшегийн философи

өвд эерэг утгатай үнэлгээ өгсөн юм. Түүний бичсэнээр "Ф.Ницшег уншигч бид гарч болох дөрвөн алдаанаас зайлсхийдэг байх ёстой. Үүнд: 1). Эзэрхэх хүсэл эрмэлзэлд холбогдох (эзэрхэх хүсэл эриэлзэл гэдэг бол "ноёлох" гэсэн "шунахайрал" буюу "засаг барих хүсэл эрмэлзэл" гэсэн утгатай хэмээн бодож болохгүй); 2). Хүчитнүүд ба сул доройчуудад холбогдох (ямар нэг нийгмийн байгууламж дахь хамгийн "чадвартнууд нь" хамгийн хүчитнүүд байдаг гэж бодож болохгүй); 3). Мөнхийн Буцалтанд холбогдох (грекчүүд, энэтхэгчүүд, египтчүүдээс зээлдсэн хуучин үзэл санааны тухай ярьж байна гэж бодож болохгүй бөгөөд орчлын тухай буюу Тэр Юмны Өөрийнх нь Буцалтын тухай, тэр юманд өөрт нь эргэж орох тухай ярьж байнад); 4). Сүүлчийн бүтээлүүдийнх нь тухай (тэдгээр бол жинхэнэ бүтээлүүдийнх нь хүрээнд багтахгүй буюу ердөө л солиорлоор гутаагдсан гэж бодож болохгүй)"²³

Ер нь экзистенциализм, постмодернизм зэргийн олон төлөөлөгч Ф.Ницшегийн философийг орчин үеийн философидолтын хэв маягт тохирсон хэллэгтэй хэмээн сурталчилж иржээ. Жишээ нь Ж.Делёз "Ницше" бүтээлдээ бичихдээ: "...Ницше афоризм, шүлэг гэсэн илэрхийллийн хоёр хэрэгслийг, философийн шинэ баримтлалыг, сэтгэгчийн ч, сэтгэлгээний ч шинэ хэв маягийг философид оруулж ирсэн юм"²⁴ гэсэн байдаг.

Харин Ж.Делёзийн энэ өгүүлсэнд нэг зүйл тодотгон дурдмаар байна. Тэрээр Ф.Ницшегийн философидолтын хоёр чухал хэрэгслийн нэгийг шүлэг гэж дурджээ. Угтаа амьдралын философийг үндэслэгч энэхүү сэтгэгч ганц шүлэг биш, уран зохиолын өөр олон төрлийг ашиглан философидож ирсэн байна. Тухайлбал түүний "Заратустра ингэж өгүүлэв" бүтээл нь туужийн хэлбэрээр бичигдсэн бөгөөд гол баатар нь Заратустра юм. Ф.Ницшегийн хамгийн сүүлчийн бүтээл, нэгэн төрөл философи намтар нь болсон "Ессе Ното" бүтээлийг нь зарим судлаач "жинхэнэ филологи роман" гэж дүрслэн бичсэн байдаг²⁵. Гэхдээ энд нэг зүйлийг зориуд тэмдэглэн хэлэх нь зүйтэй. Үүнд, Ф.Ницшегийн бүтээлүүд бол шүлэг, тууж, роман зэрэг уран зохиолын төрлөөр бичигдсэнээрээ биш, харин философи санаа, философи ойлголтууд томъёолсноороо философийн бүтээлүүд мөн.

Үүнийг нотлох зүйл Ф.Ницшегийн зохиолуудад элбэг юм. Тухайлбал тэрээр өөрийнхөө хамгийн гол зохиол болох "Заратустра ингэж өгүүлэв" гэдэг бүтээлдээ өөрийн боловсруулсан философи, ёс зүй, үнэлэмжийн онол зэрэгт холбогдох ойлголт, баримтлалуудынхаа нилээдийг нь ерийн ухамсарын төвшиний юм уу өдөр тутмын хэрэглээний үгнүүдээр гол нь

ёжиж, шоочилж юмуу өргөмжлөн дээдэлсэн утгаар нэрлэсэн аж. Тийм үгнүүдийн зарим нь янз бүрийн зэрэг дэвийн болон ажил төрлийн хүмүүсийн ерөнхий нэр, зарим нь амьтны нэр, зарим нь газар усны нэр, зарим нь эртний ард түмнүүдийн шидэт домгийн баатруудын нэр байдаг.

Ф.Ницшегээс тусгай нэрийн зориулалттай ашигласан тэдгээр үгс нь онолын хувьд философи ба нийгмийн сэтгэлгээний утга илэрхийлдгийн зэрэгцээ хэл зүйн үйл давхар гүйцэтгэдэг. Үүнд, зохиолын гол баатар Заратустрагийн дүрийг тодотгосон бусад баатрын нэрс ба тэдний авир үйлдлийн илэрхийлэл болж өгдөг байна.

Судлаачид "Заратустра ингэж өгүүлэв" зохиолын тийм баатруудын үг ба үйлдэлээр Ф.Ницше ямар философи санаа, ялангуяа ёс зүй, шашин судлал, үнэлэмжийн онол зэрэгт хамаарах ямар ямар мэдлэг илэрдэг талаар өөр өөрийн тайлбарыг хийдэг байна. Жишээ нь, Ж. Делёзийн "Ницше" гэдэг бүтээлд Ф.Ницшегийн "Заратустра ингэж өгүүлэв" зохиол болон өөр зарим бүтээлд нь гардаг философийн ба нийгэм, хүмүүнлэгийн ухааны ойлголтуудын болон зохиолын баатруудын нэрний утгыг дараах байдлаар тайлбарласан юм. Үүнд:

- Ирээдүйн философич. Энэ бол эмчлэгч буюу ёс журам бүтээгч мөн.
- Цагаа олоогүй философи. Энэ бол жинхэнэ философи буюу ирээдүйн философи мөн.
- Хүсэл эрмэлзэл. Энэ бол хүчинд хүч харьцахуй мөн.
- Эзэрхэх хүсэл эрмэлзэл. Энэ бол бүтээгээд өгөхүй мөн.
- Нигилизм. Энэ бол сөрөг хүч, үгүйсгэх хүсэл эрмэлзэл хоёр түгээмэл ялалтанд хүрдэг байдал мөн.
- Бурхан тэнгэрийн үхэл. Энэ бол өөрийн болгох агшин мөн.
- Бататгал (утверждение). Энэ бол хүсэл эрмэлзлийн хамгийн дээд чадал мөн.
- Дионис. Энэ бол тухайн учралд үндэслэн тохиолдол хүчийг тогтоогч; хөнгөмсөг, шооч, бүжиглэгч тоглоомчин мөн.
- Ариадна. Энэ бол Дионисийг болон дионисон философийг тодорхойлогч янз бүрийн харилцааг бүхэллэг бслгогч мөн.
- Буцалт. Энэ бол бүрэлдлийн ахуй, олны нэгдэл, тохиолдлын зайлшгүй мөн
- Сүүлчийн хүн ба мөхлийг хүсдэг хүн. Энэ бол төгсгөлийн агшин мөн.
- Үлэмж хүн. Энэ бол бататгаж болох бүгдийг төвлөрүүлсэн хүн; байгаа бүхний дээд хэлбэр, сонгосон Ахуйн төрөлт ба субъектив эхлэл мөн.

- Бүргэд, могой хоёр. Энэ бол Заратустрагийн амьтад, үүнд Мөнхийн буцалтыг илэрхийлдэг амьтад мөн.
- Тэмээ ба илжиг. Энэ бол цөлийн амьтад, үүнд дарамтыг цөл хүртэл тээдэг амьтад. Илжиг нь дээд хүмүүсийн бурхан тэнгэр мөн.
- Аалз (Тарантул). Энэ бол өш хонзонгийн сүнс, ёс суртахууны тороор зэвсэглэгч мөн.
- Алиа салбадай (сармагчин, одой хүн буюу шулмас). Энэ бол Заратустраг хонзогнон шоолооч, номлолыг нь гуйвуулагч мөн.
- Өширхөл. Энэ бол "чамаас боллоо, чи л буруутан" гэдэг сэтгэлийн зүхэл.
- Буруу гэмшил. Энэ бол "надаас боллоо, би л буруутан" гэж сэтгэл зовуурилдаг интроекцийн агшин.
- Христос (Ариун Павел (Библийн монгол орчуулганд заримдаа "Паул" гэж галигладаг), бурхан багш хоёр). Энэ бол нигилизмийн чухал шат, үүнд жүүд шашны өширхлийг халж бий болсон буруу гэмшилийн шат, гэхдээ амьдралд өшрөн дайсагнасан тийм санаачлага мөн.
- Дээд хүмүүс. Тэд олон байдаг. Дээд хүмүүс бол Бурхан тэнгэрийг нас барсны дараа бурхан тэнгэрлэг үнэлэмжүүдийг хүн төрөлхтний үнэлэмжүүдээр сольдог. Бурхан тэнгэрийн оронд хүнийг дэвшүүлдэг. Заратустраг шоолдог боловч алиа салбадайд ойр байдаг хүмүүс мөн. Ф.Ницше дараахь маягийн дээд хүмүүсийг онцолсон. Үүнд:
 1. Сүүлчийн пап лам. Энэ бол Бурхан тэнгэр үхсэн гэдгийг мэддэг, гэхдээ Бурхан тэнгэр байнгын нигүүлсэх сэтгэлээсээ болж дотроо багтран, хүмүүст хайраа цаашид өгөх тэнхэлгүй болсон гэж боддог хүн мөн.
 2. Хоёр ноён. Эд нар бол "сайхан сэтгэлийн" үйлдлийн төлөөлөл мөн. Уг үйлдлийн зорилго нь хүнийг төлөвшүүлэн өсгөх, эрх чөлөөтэй болгоход оршдог. Үүнийхээ тулд хамгийн хатуу ширүүн хэрэгслийг ч гэсэн ашигладаг. Ийм учраас хоёр ноён байгаа. Нэг нь зүүн буюу хэрэгслийн ноён; нөгөө нь баруун буюу зорилгын ноён аж. Энэ хоёр ноён дүүрэн ачаатай илжиг тууж явдаг. Тэр илжгийг нь дээд хүмүүс шинэ бурхан тэнгэрээ болгосон.
 3. Хамгийн жигшүүрт хүн. Энэ бол Бурхан тэнгэрийн нигүүслийг үл тэвчсэндээ Түүнийг алсан хүн. Гэхдээ хамгийн жигшүүрт хүн бол бас л урьдын хүн, бүр түүнээс ч муу хүн. Учир нь өөрийнхөө төлөө үхсэн Бурхан тэнгэрийг юманд үл бодон, хүний нигүүслийг, харцын нигүүслийг урьтал болгодог нь тэвчишгүй байдаг. Чухамхүү хамгийн жигшүүрт хүн л Илжгэнд залбирч мөргөхөд дээд хүмүүсийг түлхдэг.

4. Хувалзан хүн. Энэ бол бурхан тэнгэрлэг үнэлэмж, шашин зэргийг, түүгээр зогсохгүй ёс суртахууныг танин мэдэхүйгээр орлуулахыг хүсдэг хүн мөн. Хамгийн өчүүхэн юмны маш нарийвчилсан мэдлэгээр "аугаа" бүрхэг үнэлэмжид бид бишрэхийг орлуулдаг хүмүүс мөн. Угтаа танин мэдэхүй бол хувалз юм; тэр нь амьдралыг чичилж, амьдралыг бүтээж, адалж ирсэн ёс суртахуун, шашны пайзыг шилжүүлж авсан гэдгийг хувалзан хүн мэддэггүй.

5. Сайн дурын гуйранч. Энэ бол танин мэдэхүйгээс ч татгалзагч, аз жаргалаас өөр юманд үл итгэгч хүн. Сайн дурын гуйранч бол аз жаргалыг Бурхан тэнгэрээс биш, харин газар дэлхийгээс хайдаг. Гэхдээ тэр нь ямар ч балай хүнд боловч жаргал өгдөг байх ёстой. Өш хонзон, буруу гэмшилд автсан харц хүнд аз жаргал байдаггүй.

Хүн төрөлхтөн аз жаргалаа үхрээс олно гэж сайн дурын гуйранч үздэг.

6. Элдэвлэгч. Энэ бол Бурхан тэнгэрийн эзэгнэлийн үед ч, түүнээс хойш ч буруугаа гэмшигч болж маяглагч хүн. Элдэвлэгч бол Ариадна ч болж, яруу найрагч юмуу атеист ч болж хүжиглэгч мөн. Худалч ба аашлахын донтон. "Энэ миний буруу" гэдэг нь өөрийгөө өрөвдөн хайрлуулах, хүчтэнгүүдийг буруутан гэж итгүүлэх, амьтан бүгдийг ичээх, өөрийн хороор бүгдийг хордуулах зэрэг зорилготой байдаг.

7. Хэрмэл сүүдэр. Энэ бол Бурхан тэнгэр эзэгнэж буй үед, түүний үхсэний дараа, танин мэдэхүйд, жаргалтай үед зэрэг хэзээ л бол хэзээ, хаана л бол хаана зорилготой байдаг соёлын үйл ажиллагаа мөн. Гэхдээ зорилгодоо хэзээ ч хүрдэггүй. Учир нь, түүний зорилго бол Сүүдэр төдий байдаг. Энэ сүүдэр бол Заратустрагийнх бөгөөд Заратустраг цаг ямагт, газар сайгүй дагаж, зөвхөн Өөрчлөлтийн аугаа их цагууд болох үд дунд, шөнө дунд хоёрт л алга болдог.

8. Төлөгч. Энэ бол нигилизмийн сүүлчийн шатыг угтан мэдээлэгч мөн. Энэ бол хүн Бурхан тэнгэрийг байранд нь тавих гэсэн чармайлтаа бүтэхгүйг мэдэхлээрээ юу ч үгүйг гэх хүсэл эрмэлзлийг биш, харин хүсэл эрмэлзлийн юу ч үгүйг сонгодог тийм цагийн угтан мэдээлэхүй байдаг. Тийнхүү Төлөгч бол сүүлчийн хүнийг зөгнөдөг. Тэрээр нигилизмийн төгсгөлийг зөгнөдгөөрөө дээд хүмүүсээс цааш явдаг. Гэвч мөхлийг хүсдэг хүн болох сүүлчийн хүний замд байдаг зүйл нь Төлөгчөөс мултардаг.

"Заратустра ингэж өгүүлэв" гэдэг Ф. Ницшегийн зохиол дахь философийн ба хүмүүнлэгийн мэдлэгийн бусад зарим салбарын ойлголт, үндэслэлүүдийн заримынх нь хэл зүйн илрэлүүдийг Жиль Делёз хэрхэн тогтоосоныг дурдахад ийм байна.

Гэвч Ж. Делёзийн эл судалгаа нь Ф. Ницшегийн философидолтын агуулгыг тогтоож буй янз бүрийн ойлголт, үндэслэл, санааны зөвхөн заримыг онцолжээ. Ийм судалгааг цаашид улам гүнзгийрүүлэн өргөтгөх шаардлагатай юм.

Миний хувьд зарим амьтны нэрээр үнэлэмжийн философийн утгатай ямар ямар ойлголт Ф. Ницше илэрхийлсэнийг авч үзэх зорилт тавьж байлаа. Түүнийхээ үр дүн болсон зарим ойлголтыг дурдъя ("Заратустра ингэж өгүүлэв" гэдэг зохиолтой танилцаж хараахан амжаагүй уншигч нарт хандаж нэг тайлбар хэлэхэд энэ бүтээл дэх Заратустра бол эртний Дорно дахины ард түмнүүдийн, ялангуяа иранчуудын шидэт дсмгийн соён гэгээрүүлэгч ба шид үзүүлэгч баатрын нэр юм. Уг зохиолд Заратустрагийн хэлж буй үг бүхэн нь Ф. Ницшегийн өөрийнх нь үзэл бодлыг илэрхийлдэг). Үүнд:

- Хонь. Энэ бол хуучинсаг, бэртэгчин эрдэмтэн мөн.²⁶ Тийм эрдэмтэн бол бэлэн хоол тэжээлийг (өөрөөр хэлбэл бусдын ба өөрийн боловсруулсан онолыг) хонь лугаа адил хаман идэж, идсэнээ эрүүлэж гарган хэвж байдаг.

- Үхэр. Энэ бол бэлэн жаргал эдлэгч.²⁷ Үхэр бол тухлан хэвтчихээд бодох санах юмгүйгээр айван тайван хэвж байдаг нь сайн дурын гуйранчид жинхэнэ жаргал санагддаг.

- Сүрэг. Энэ бол шашны биш эрдэм номын дундаж хүмүүс мөн.²⁸ Тийм хүмүүс нэр хүндтэй цөөнхөд хөтлөгдөж байдаг нь малчин ба малч нохойн харгалзаан дахь сүрэг лүгээ адил байдаг гэж Ф. Ницше зүйрлэсэн юм.

Энэ мэтээр "Заратустра ингэж өгүүлэв" зохиолд буй өч төчнөөн олон нэр үгэнд Ф. Ницше ямар утга оруулсаныг мэдэх шаардлага байдаг.

Ф.Ницшегийн философийн талаархи хоорондоо ялгаа бүхий үнэлэмжүүд бол энэ философийг цаашид судлан сурталчилах ажиллагааг хянуур болгоомжтой, сайн ул үндэстэй явуулдаг байхыг шаардаж байгаа болно.

Резюме

Данная статья начинается рассмотрением состояния ницшевеведения, которое ведётся на Западе в течении XX века. Автор статьи считает, что существуют 2 основных вида ницшевеведения которые условно можно различить как биографическое и теоретическое, несмотря на то, что они тесно связаны в силу того, что философствование Ф.Ницше - это философское размышление фактически собственного жизненного пути самого философа.

Немалое внимание в статье автор уделяет философским положениям труда Ф.Ницше "Так говорил Заратустра", в частности,

предпринята попытка раскрытия философского смысла отдельных слов, которые обозначают конкретные персонажи, задействованные в этой философской повести.

Автор статьи также рассматривает отдельные положительные и отрицательные оценки по философским взглядам Ф.Ницше, проводя определенные аргументы.

Иш татсан зохиол

1. Оросын философич К.А.Свасьян 1990 онд Ф.Ницшегийн гол зохиолуудаар 2 боть эмхтгэл ном гаргахдаа бичсэн удиртгал өгүүлэлдээ (К. А. Свасьян. Вступительная статья.-Фридрих Ницше. Сочинения в двух томах. Т.1, с.9) энэ судлаач эмэгтэйн гол зохиолыг дурдсан байна. Үүнд: Forster-Nietzsche E. Das Leben Friedrich Nietzsches. 1. Abt. Bd 2. Leipzig, 1904. S.15.

2. Мөн К.А.Свасьян (там же, с.10) К. А. Бернуллаас онцолсон нэг зохиол дурдахад: Bernoulli C.A. France Overbeck und Friedrich Nietzsche. Eine Freundschaft. Bd 2. Iena, 1908.

3. М.Магид холбогдох мэдээг: Д.Төмөрхуяг. Фридрих Ницше. Цадиг жигүүрт үгс. УБ., 2005, 19 дэх талаас дам авав.

4. Цит. по: кн. К.А.Свасьян. Фридрих Ницше:мученик познания. Вступительная статья.-Фридрих Ницше. Сочинения в двух томах. Т.1, М., 1990, с.23

5. Цит по: там же, с.24

6. там же

7. К.Jaspers. Nietzsche. В.,1950

8. М.Хайдеггер 1947 онд "Ницшегийн "бурхан тэнгэр үхсэн" гэдэг үг" хэмээх өгүүлэл бичсэн бол 1961 онд "Ницше" гэдэг нэртэй хоёр боть ном хэвлүүлжээ. (М.Heiddeger. Nietzsche.Bd. 1-2, Stuttg., 1961) Гэхдээ энэ ном нь 1936-1940 оны хооронд М.Хайдеггерийн бэлтгэсэн лекцүүд,бичсэн өгүүллэгүүдийнх нь шилмэл түүвэр бөгөөд "Ницше" гэдэг гарчиг түүндээ өгсний үндсэн шалтгаан бол философийг хэвшмэл сэтгэлгээ болгож үзээгүй Ф.Ницшегийн арга барилыг М.Хайдеггерийн дэмжсэний нэг чухал баталгаа юм.

9. См. Об этом напр. : Жак Деррида. Шпоры: стили Ницше.-Философские науки. 1991, №2; Түүнээс гадна Ж.Деррида "Грамматологийн тухай" , "Бичиг ба ялгаа" зэрэг бүтээлдээ сонгодог биш философийн олон

гарамгай төлөөлөгчдийн текстүүд сонгодог логосын (зарчмын) хүрээнээс хэрхэн хальсныг харуулахдаа Ф.Ницшегийн текстүүдийг нэг том жишээ болгосон гэж судлаачид үздэг.

10. См. об этом напр.: Мишель Фуко. Ницце, Фрейд, Маркс – Кентавр, 1994, №2. Ер нь түүний олон бүтээлд нь А.Лопенгауэр, Ф.Ницце зэрэг философичдын боловсруулсан волюнтаризмын нөлөө хүчтэй байдгийг судлаачид өгүүлсэн байдаг.

11. Жиль Делёз. Ницце. СПб., 1997 G.Delèuze. Nietzsche. Paris, 1965.

12. Напр.: С.Ф.Одуев. Тропами Заратустры (влияние ницшеанства на немецкую буржуазную философию). М., 1971

13. К.А.Свасьян. Фридрих Ницце: мученик познания.- Фридрих Ницце. Сочинения в двух томах. Том 1, М., 1990 с. 5-46

14. Жишээ нь: Ф. Ницше. - Философийн толь. Орос хэлнээс орчуулсан хамтын бүтээл. УБ., 1990, 292 дахь тал

15. Жишээ нь: Ц.Гомбосүрэн. Орчин үеийн хөрөнгөтний философийн иррационалист чиглэлүүд. УБ., 1989, I бүлэг, 1§ (13-19 дэх тал)

16. Жишээ нь :Ш.Ганхуяг. М.Гантуяа философийн түүхэн тойм. УБ., 2002, 331-337 дахь тал. Түүнээс гадна Философи. Сурах бичиг. УБ., 2002. номны 176-178 дахь талд ганц Ницшегийн биш, харин нийт "амьдралын философийн тухай" ерөнхий шинжүүдийг сэтгэлгээний эерэг үр дүн болж буй талыг нь онцолж товч тайлбарлажээ.

17. Д.Төмөрхуяг. Фридрих Ниццэ. Цадиг, жигүүрт үгс. УБ., 2005; Бас яруу найрагч Г.Аюурзана шилдэг философичдын санааг цэгцлэн хураангуйлсан "шинэ үеийн номын сан" цуврал ном гаргах санаа өвөрлөн улмаар анхныхыгаа 2000 онд хэвлүүлжээ. Тэнд Ф.Ницшегийн намтрын чухал мэдээ болон зарим философи санааг нь багтаасан зүйл байна. (Г.Аюурзана. 2x2 6 буюу суут 60 сэтгэгч. "Шинэ үеийн номын сан" цуврал №1. УБ., 2000, 310-317 дахь талд энэ тухай үзнэ үү).

18. О.Чимэг Ф.Ницшегийн философи дахь эзэрхэх хүсэл зоригийн тухай сургаал.- Эрдэм шинжилгээний бичиг. №185 (12). Философи, шашин судлал. УБ., 2002, 67-77 дахь тал.

19. См.: А.А.Лаврова. Ницце.- Современная западная философия. Словарь. 2-ое издание, переработанное и дополненное. Составители и ответственные редакторы В.С.Малахов, В.П.Филатов, с. 294

20. См. об этом: Бертран Рассел. История западной философии. Ростов-на-Дону. М., 1998, с. 854

21. Там же, с. 868

22. См. Об этом напр.: Предисловие к книге "Фридрих Ницше. Сборник. Мн., 1998", с.9

23. Ж.Делёзийн эл үнэлгээг миний иш татаж буй эх сурвалж нь: Постмодернизм. Энциклопедия. Мн., 2002, с. 520

24. Жиль Делёз. Ницше. Пер. с фр. СПб., 2001. Энэ ишлэлийг инернет дэх уг номын хуулгаас авав.

25. К.А.Свасьян. Примечания.- Фридрих Ницше. Сочинения в двух томах. Т.2, с.805

26. Ф. Ницше "хонь" гэдэг нэрээр ямар эрдэмтэнг илэрхийлдгийг мэдэх бололцоо олгодог ("Заратустра ингэж өгүүлэв" зохиол дахь) мөрүүд: Фридрих Ницше. Сочинения в двух томах. Т.2, с.90-91

27. " Үхэр" гэдэг үг Ф. Ницшегийн хувьд ямар ойлголт илэрхийлдгийг нилээд тодорхой болгодог мөрүүд: там же, с. 193-196

28. Энэ тухай ойлгоц авахад хамгийн оновчтой санагдаж буй мөрүүд: там же, с. 43-45